



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 2/568

Хэрлэн сум

Хүнсчидийн форум зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай 16 дугаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж буй “Хүнсчидийн форум” арга хэмжээнд 9,992,000 (есөн сая есөн зуун ерөн хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023
оны 11 дугаар сарын 10-ны
1568 дугаар захирамжийн хавсралт

“ХҮНСЧИДИЙН ФОРУМ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт дүн ₮
1	Лекторын төлбөр	хүн/өдөр	1	1 100 000	1 100 000
2	Хулдаасан хэвлэл /баннер/	мкв	24.6	20 000	492 000
3	Цайны завсарлага	ш	200	5 100	1 020 000
4	Өдрийн хоол	ш	200	30 000	6 000 000
5	Мандат	ш	200	1 500	300 000
6	Бал, дэвтэр	ш	200	5 400	1 080 000
	Нийт дүн				9 992 000